ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 814/А0171099 Улаанбаатар хот

САГ-2026/35 З/ИА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 9,900,000.00 */есөн сая есөн зуун мянган/* төгрөгийн агааржуулалтын систем, 15,003,500.00 */арван таван сая гурван мянган таван зуу/* төгрөгийн компьютер, 19,200,000.00 */арван есөн сая хоёр зуун мянга/* төгрөгийн барилгын засварын материал, нийт 44,103,500.00 */дөчин дөрвөн сая нэг зуун гурван мянга таван зуу/* төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын *4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй хөрөнгө, бараа материал бэлтгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /Б.Ганзориг/, Ерөнхий нягтлан бодогч /Ц.Болортуяа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\20260316 SAG-51.Docx

1526181097

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр          Дугаар 813/А0171099          Улаанбаатар хот

САГ-2026/353/ХА-СТА-ТШ3

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн санхүүгийн 2 ажилтанд 1 дүгээр сард илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчидад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн, нийт 2,316,739.00 */хоёр сая гурван зуун арван зургаан мянга долоон зуун гучин ес/* төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батласан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчидад нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо холбогдох журмыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /Б.Ганзориг/, Ерөнхий нягтлан бодогч /Ц.Болортуяа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\20260316 SAG-51.Docx

1526181093

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 812/А0171099 Улаанбаатар хот

САГ-2026/353/КА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төвийн захирлын 2025 оны Б/67 дугаар тушаалаар байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн чанар, үр дүнгээр 80 оноогоор үнэлэгдсэн гэсэн үндэслэлээр санхүүгийн 3 албан хаагчид нийт 4,397,000.00 */дөрвөн сая гурван зуун ерэн долоон мянга/* төгрөгийн урамшууллыг олгосон нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллалтай давхардуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараахь хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "Хууль тогтоомжид заснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-д "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж, урамшуулж болно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын *4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгодог зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /Б.Ганзориг/, Ерөнхий нягтлан бодогч /Ц.Болортуяа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР В.ЭРДЭНЭЦОГТ
АХЛАХ АУДИТОР М.ПАГАМДУЛАМ
АУДИТОР Б.ОТГОНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 811/А0171099 Улаанбаатар хот

САГ-2026/353/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх эсийн шинжилгээний 220,071,000.00 */хоёр зуун хорин сая далан нэгэн мянга/* төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэж, хангамж, бараа материалын зардал, эд хогшил урсгал засварын зардал, сургалтын зардал зэрэгт зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6.3-т "Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.3.1-т "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх эсийн шинжилгээний орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /Б.Ганзориг/, Ерөнхий нягтлан бодогч /Ц.Болортуяа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-51.Docx

1526181091

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 16 өдөр Дугаар 810/A0171099 Улаанбаатар хот

САГ-2026/353/ИА-СТА-ПШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмгэг судлалын үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төв нь жилийн эцэст 14 харилцагч байгууллагатай нийт 510,563,000.00 */таван зуун арван сая таван зуун жаран гурван мянга/* төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын *4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"* гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жилийн эцэст авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /Б.Ганзориг/, Ерөнхий нягтлан бодогч /Ц.Болортуяа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | В.ЭРДЭНЭЦОГТ |
| АХЛАХ АУДИТОР | М.ПАГАМДУЛАМ |
| АУДИТОР | Б.ОТГОНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

## ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

**Байгууллагын нэр: Эмгэг судлалын үндэсний төв**
**Аудитын код: САГ-2026/353/НА-СТА-ТШЗ**
**Тайлант хугацаа: 2025.01.01-2025.12.31**

| № | АГАДҮТ | АГАДҮТ-ийн дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /төгрөгөөр/ | Материаллаг эсэх | Үр өгөөжөөр тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт: Стандартын заалт | Шалгуур үзүүлэлт: Хууль тогтоомжийн заалт | Алдаа, зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4.00 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | Санхүүгийн тайлангийн алдаа | | | | | | | | | | | | |
| 1 | Дансны үлдэгдэлтэй холбоотой | Үндсэн хөрөнгийн дансгай холбоотой | Үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 6,983.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 6,983,295.42 | материаллаг бус | үгүй | УСНББОУС-2 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах" заасантай нийцээгүй байна. | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой | Залруулах | | | |
| | Залруулах алдааны дүн | | | 1,052,086,225.00 | | | | | | | | | |
| | Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил | | | | | | | | | | | | |
| 2 | Ажил гүйлгээтэй холбоотой | Орлогын дансгай холбоотой | Тус төв нь үндсэн үйл ажиллагааны орлогод оруулж төлөвлөхгүйгээр нэмэлт санхүүжилтийн дансанд жил бүр хийгддэг эмгэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх эсийн шинжилгээний орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэн нэмэлт санхүүжилтийн дансанд 220,071.0 мянган төгрөгийг төвлөрүүлж хангамж, бараа материалын зардал, эд хогшил урсгал засварын зардал, сургалтын зардал зэрэгт тус тус зарцуулсан байна. | 220,071,000.00 | материаллаг | үгүй | УСНББОУС-1 | Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", " 6 дугаар зүйлийн, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 6.3-т "Энэ хуулийн 5.1.2-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.3.1-т "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бүүрүүлах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна. | Орлого бүрдүүлэлттэй холбоотой | Албан шаардлага өгөх | | | |
| 3 | Ажил гүйлгээтэй холбоотой | Цалингийн зардалтай холбоотой | Тус төвийн санхүүгийн 2 ажилтанд 1-р дүгээр сард илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчидад нэмэгдэл хөлс олгох журам"-д заасан тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн 28 цагийн нийт 2,316.7 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна. | 2,316,739.74 | материаллаг бус | үгүй | УСНББОУС-2 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчидад нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т заасанаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрахгүй байна" гэсэн заалттай нийцэгүй; | Арвилан хямналт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой | Албан шаардлага өгөх | | | |
| 4 | Дансны үлдэгдэлтэй холбоотой | Бараа материалын дансгай холбоотой | Бараа материалын дансанд 788.8 мянган төгрөгийн 4 ширхэг үндсэн хөрөнгийн шинжтэй тавилга эд хогшил, багаж техник хэрэгсэл бүртгэсэн байна. | 788,790.00 | материаллаг бус | үгүй | УСНББОУС-19 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна. | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой | Зөвлөмж өгөх | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Ажил гүйлгээтэй холбоотой | Зардлын данстай холбоотой | Төвийн захирлын 2025 оны Б/67 дугаар тушаалаар байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн чанар, үр дүнгээр 80 оноогоор үнэлэгдсэн гэсэн үндэслэлээр санхүүгийн 3 албан хаагчид нийт 4,397.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлснийг дүгнэж олгодог улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулсан байна. | 4,397,000.00 | Материаллаг бус | үгүй | УСНББОУС 2 | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-д "Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна", 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-д "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж, урамшуулж болно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшууллын доод хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн. | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Албан шаардлага өгөх | | | |
| 6 | Ажил гүйлгээтэй холбоотой | Зардлын данстай холбоотой | Тайлант онд сургалт, томилолт, харуул хамгаалалтын зардал зэрэг нийт 72,757.4 мянган төгрөгийн зардлыг авлага, өглөгийн тооцоо үүсгэлгүй зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. | 72,757,385.40 | материаллаг | үгүй | УСНББОУС 2 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл суурьтаар хөтөлнө" гэж заасантай нийцээгүй | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Зөвлөмж өгөх | | | |
| 7 | Ажил гүйлгээтэй холбоотой | Худалдан авах ажиллагаатай холбоотой | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 9,900.0 мянган төгрөгийн агааржуулалтын систем, 15,003.5 мянган төгрөгийн 3 ширхэг компьютер, 19,200.0 мянган төгрөгийн барилгын засварын материал, нийт 44,103.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. | 44,103,450.00 | материаллаг | үгүй | УСНББОУС 2 | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Албан шаардлага өгөх | | | |
| 8 | Дансны үлдэгдэлтэй холбоотой | Авлагын данстай холбоотой | Тус төв нь 14 байгууллагатай нийт 510,563.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. | 510,562,978.00 | материаллаг | үгүй | УСНББОУС 2 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага бө төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, балтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийх, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай тус тус нийцээгүй | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Албан шаардлага өгөх | | | |
| Зөрчлийн дүн | | | | 854,977,343.14 | | | | | | | | | |
| Нийцлийн аудиттай холбоотой | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Ажил гүйлгээтэй холбоотой | Цалингийн зардалтай холбоотой | Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг тогтоож батлаагүй байхад үйлчилгээний ажилчид сар бүр 10-25 хувиар ур чадварын нэмэгдлийг бодож, нийт 51,715.9 мянган төгрөгийг олгосон байна. | 51,715,859.62 | материаллаг | | УСНББОУС-2 | Монгол Улсын засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 3-т "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно" 4-т "Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно" гэсэн заалттай нийцэхгүй. | Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | Дараагийн аудитаар анхаарах асуудалд оруулах | | | |
| | | | Нийцлийн зөрчлийн дүн | 51,715,859.62 | | | | | | | | | |
| | | | Нийт зөрчлийн дүн | 906,693,202.76 | | | | | | | | | |

Бэлтгэсэн:

Аудитор........................................Б.Отгонцэцэг Огноо:

Ахлах аудитор ........................................М.Пагамдулам

Хянасан:

Аудитын менежер........................................В.Эрдэнэцогт Огноо:

Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор ........................................Ц.Наранчимэг Огноо:

Танилцаж зөвшөөрсөн:

Эмгэг судлалын үндэсний төвийн:

Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч ........................................Ганзориг Огноо:

Ерөнхий нягтлан бодогч: ........................................Ц.Болортуяа Огноо:

ШТТ9985 9022030415 9129267